



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Дуу бүжгийн чуулгын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СЭА-2022/144/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
	Утас:7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
	Аудитын менежер: Б.Батмөнх
	Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
	Ахлах аудитор: Т.Болор
	Утас: 7036-2442 Цахим хаяг: bolort@audit.gov.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-12
3. Аудитын тайлан	13
3.1. Ерөнхий зүйл	13
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.7. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8. Аудитын гол асуудал	17
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/144-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын Дуу бүжгийн чуулгын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Дуу бүжгийн чуулгын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	165,866,795.00	169,029,695.00
35	БАРАА МАТЕРИАЛ	165,866,795.00	169,029,695.00
35400	Хангамжийн материал	165,866,795.00	169,029,695.00
35410	Бичиг хэргийн материал	154,420.00	214,420.00
35420	Аж ахуйн материал	19,802,007.00	19,466,107.00
35450	Барилгын засварын материал	7,155,100.00	4,620,100.00
35470	Бусад хангамжийн материал	138,755,268.00	144,729,068.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,308,086,509.93	1,375,735,352.79
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,308,086,509.93	1,375,735,352.79
39200	Биет хөрөнгө	1,204,786,509.89	1,272,685,352.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,143,232,200.00	1,143,232,200.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-60,605,174.95	-86,125,388.23
39203	Авто-тээврийн хэрэгсэл	89,440,000.00	89,440,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-89,440,000.00	-34,879,999.96
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	234,393,270.33	212,214,024.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	-160,958,330.37	-118,617,627.20
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,927,588.30	21,767,426.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-39,312,333.35	-6,919,136.96
39214	Бусад үндсэн хөрөнгө	57,381,313.56	71,864,613.56
39215	Хуримтлагдсан элэгдэл	-16,272,023.63	-19,290,758.83
39300	Биет бус хөрөнгө	103,300,000.04	103,050,000.08
39301	Программ хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-499,999.96	-749,999.92
39303	Бусад биет бус хөрөнгө	102,300,000.00	102,300,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,473,953,304.93	1,544,765,047.79
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,473,953,304.93	1,544,765,047.79
51	Засгийн газрын хувь оролцоо	1,473,953,304.93	1,544,765,047.79
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,143,543,879.70	1,143,543,879.70
51200	Хуримтлагдсан үр дүн	-325,380,165.70	-254,568,422.84
51210	Өмнөх үеийн үр дүн	-291,406,234.31	-325,380,165.70
51220	Тайлант үеийн үр дүн	-33,973,931.39	70,811,742.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	655,789,590.93	655,789,590.93
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,473,953,304.93	1,544,765,047.79

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	631,728,848.69	851,239,048.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,741,000.00	173,910,074.73
120	Нийтлэг татварын бус орлого	11,741,000.00	173,910,074.73
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	11,550,000.00	166,260,074.73
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	191,000.00	7,650,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	619,987,848.69	677,328,973.47
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,556,250.00	6,583,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	4,820,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,556,250.00	1,763,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	613,431,598.69	670,745,973.47
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	613,431,598.69	670,745,973.47
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	665,702,780.08	780,427,305.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	665,702,780.08	780,427,305.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	665,202,430.08	731,932,005.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	456,936,382.15	470,845,730.91
210101	Үндсэн цалин	382,020,727.94	375,199,009.16
210102	Нэмэгдэл	29,701,140.28	81,153,591.00
210104	Урамшуулал	23,949,229.00	0
210105	Гэрээт ажлын хөлс	21,265,284.93	14,493,130.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,653,476.74	61,295,357.58
210201	Тэтгэврийн даатгал	39,576,156.76	43,289,461.32
210202	Тэтгэмжийн даатгал	4,370,243.23	4,750,458.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,770,658.99	3,787,765.33
210204	Ажилгүйдлийн даатгал	1,087,769.73	816,459.75
210205	Эрүүл мэндийн даатгал	8,848,648.03	8,651,212.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,762,429.80	75,039,104.98
210301	Гэрэл, цахилгаан	3,552,770.00	3,230,298.79
210302	Түлш, халаалт	68,283,179.80	71,398,486.19
210303	Цэвэр, бохир ус	1,926,480.00	410,320.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,151,160.00	10,545,380.00
210401	Бичиг хэрэг	1,328,120.00	550,230.00
210402	Тээвэр, шатахуун	1,655,040.00	1,224,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	732,120.00	784,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	35,880.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	400,000.00	7,985,900.00
2105	Нормативт зардал	192,694.00	59,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	192,694.00	59,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,869,600.00	2,934,650.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	211,950.00	399,650.00
210604	Урсгал засвар	2,657,650.00	2,535,000.00
2107	Томилолт, зочны зардал	298,200.00	28,000.00

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Дуу бүжгийн чуулгын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	298,200.00	28,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,410,500.00	12,223,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,290,500.00	12,123,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,927,987.39	98,961,281.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,921,500.00	350,050.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	56,006,487.39	98,611,231.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,350.00	48,495,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	48,495,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	47,778,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	716,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	350	0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	350	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-33,973,931.39	70,811,742.86
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-33,973,931.39	70,811,742.86

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,143,543,879.70	655,789,590.93	-325,380,165.70	1,473,953,304.93
2	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,143,543,879.70	655,789,590.93	-325,380,165.70	1,473,953,304.93
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,143,543,879.70	655,789,590.93	-325,380,165.70	1,473,953,304.93
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
6	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
7	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
8	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
9	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
10	Тайлант үеийн үр дүн	0	0	70,811,742.86	70,811,742.86
11	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,143,543,879.70	655,789,590.93	-254,568,422.84	1,544,765,047.79

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	619,987,848.69	677,338,023.47
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	619,987,848.69	677,338,023.47
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,556,250.00	6,592,050.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	4,820,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	350
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,556,250.00	1,771,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	613,431,598.69	670,745,973.47
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	613,431,598.69	670,745,973.47
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	616,057,848.69	677,338,023.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	616,057,848.69	677,338,023.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	615,557,498.69	628,833,673.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	456,936,382.15	470,845,730.91
210101	Үндсэн цалин	382,020,727.94	375,199,009.16
210102	Нэмэгдэл	29,701,140.28	81,153,591.00
210104	Урамшуулал	23,949,229.00	0
210105	Гэрээт ажлын хөлс	21,265,284.93	14,493,130.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,653,476.74	61,295,357.58
210201	Тэтгэврийн даатгал	39,576,156.76	43,289,461.32
210202	Тэтгэмжийн даатгал	4,370,243.23	4,750,458.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,770,658.99	3,787,765.33
210204	Ажилгүйдлийн даатгал	1,087,769.73	816,459.75
210205	Эрүүл мэндийн даатгал	8,848,648.03	8,651,212.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,762,429.80	75,160,654.98
210301	Гэрэл, цахилгаан	3,552,770.00	3,230,298.79
210302	Түлш, халаалт	68,283,179.80	71,398,486.19
210303	Цэвэр, бохир ус	1,926,480.00	531,870.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,442,110.00	2,497,930.00
210401	Бичиг хэрэг	1,054,950.00	610,230.00
210402	Тээвэр, шатахуун	1,655,040.00	1,103,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	732,120.00	784,600.00
2105	Нормативт зардал	4,836,050.00	6,033,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,836,050.00	6,033,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,947,400.00	399,650.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,648,900.00	0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	299,350.00	399,650.00
210604	Урсгал засвар	4,999,150.00	0
2107	Томилолт, зочны зардал	298,200.00	28,000.00
210702	Дотоод албан томилолт	298,200.00	28,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,258,000.00	12,223,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,138,000.00	12,123,000.00

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Дуу бүжгийн чуулгын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	423,450.00	350,050.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	423,450.00	350,050.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,350.00	48,504,350.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	48,495,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	47,778,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	716,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	350	9,050.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	350	9,050.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,930,000.00	0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,930,000.00	0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,930,000.00	0
2200	Дотоод эх үүсвэрээр	3,930,000.00	0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,930,000.00	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-3,930,000.00	0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	694,944,300.00	670,745,973.47	24,198,326.53	96.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	694,944,300.00	670,745,973.47	24,198,326.53	96.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	646,749,000.00	622,550,673.47	24,198,326.53	96.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	480,458,000.00	470,845,730.91	9,612,269.09	98.00
210101	Үндсэн цалин	340,594,000.00	375,199,009.16	-	110.16
210102	Нэмэгдэл	124,744,000.00	81,153,591.00	34,605,009.16	65.06
210105	Гэрээт ажлын хөлс	15,120,000.00	14,493,130.75	43,590,409.00	95.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,882,100.00	61,295,357.58	3,586,742.42	94.47
210201	Тэтгэврийн даатгал	45,657,800.00	43,289,461.32	626,869.25	94.81
210202	Тэтгэмжийн даатгал	4,806,100.00	4,750,458.44	55,641.56	98.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,844,900.00	3,787,765.33	57,134.67	98.51
210204	Ажилгүйдлийн даатгал	961,200.00	816,459.75	144,740.25	84.94
210205	Эрүүл мэндийн даатгал	9,612,100.00	8,651,212.74	960,887.26	90.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85,296,100.00	75,160,654.98	10,135,445.02	88.12
210301	Гэрэл, цахилгаан	6,496,900.00	3,230,298.79	3,266,601.21	49.72
210302	Түлш, халаалт	74,851,200.00	71,398,486.19	3,452,713.81	95.39
210303	Цэвэр, бохир ус	3,948,000.00	531,870.00	3,416,130.00	13.47
2104	Хангамж, бараа материалын зардал	2,737,200.00	2,497,930.00	239,270.00	91.26
210401	Бичиг хэрэг	610,300.00	610,230.00	70.00	99.99
210402	Тээвэр, шатахуун	1,103,600.00	1,103,100.00	500.00	99.95
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,023,300.00	784,600.00	238,700.00	76.67
2105	Нормативт зардал	983,300.00	983,300.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	983,300.00	983,300.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	400,000.00	399,650.00	350.00	99.91
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	400,000.00	399,650.00	350.00	99.91
2107	Томилолт, зочны зардал	649,100.00	28,000.00	621,100.00	4.31
210702	Дотоод албан томилолт	649,100.00	28,000.00	621,100.00	4.31
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,990,000.00	10,990,000.00	0.00	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,890,000.00	10,890,000.00	0.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	100,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	353,200.00	350,050.00	3,150.00	99.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	353,200.00	350,050.00	3,150.00	99.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,195,300.00	48,195,300.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,195,300.00	48,195,300.00	0.00	100.00

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Дуу бүжгийн чуулгын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47,778,600.00	47,778,600.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	416,700.00	416,700.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	694,944,300.00	670,745,973.47	24,198,326.53	96.52
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	694,944,300.00	670,745,973.47	24,198,326.53	96.52
320001	Орон нутгийн төсвөөс	694,944,300.00	670,745,973.47	24,198,326.53	96.52
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	85	85	0.00	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	42	42	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	36	36	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	5	5	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	42	42	0.00	100.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	42	42	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	6,592,050.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	6,592,050.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	6,283,000.00
2105	Нормативт зардал	-	5,050,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	5,050,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	1,233,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,233,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	309,050.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	300,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	9,050.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	9,050.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	6,592,050.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	6,592,050.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,820,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	350.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,771,700.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын Дуу бүжгийн чуулгын /Цаашид Мандал сумын Дуу бүжгийн чуулга гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэж байх, өөрийн орлого төвлөрүүлэхтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Т.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын Дуу бүжгийн чуулгын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мандал сумын Дуу бүжгийн чуулга нь “Нийгмийн баялгийг чанартай бүтээн туурвиж, ард иргэдийн оюунд соёлын хөрөнгө оруулалт хийж хөгжүүлэх” гэсэн эрхэм зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус чуулгын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мандал сумын Дуу бүжгийн чуулгын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын Дуу бүжгийн чуулгын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 665,702.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,657.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 буюу 4,992.8 мянган төгрөгөөр урьдчилан тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мандал сумын Дуу бүжгийн чуулгын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 70,811.7 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	165,866.80	169,029.70	3,162.90
Үндсэн хөрөнгө	1,308,086.50	1,375,735.30	67,648.80
Нийт хөрөнгө	1,473,953.30	1,544,765.00	70,811.70
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,473,953.30	1,544,765.00	70,811.70
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,473,953.30	1,544,765.00	70,811.70


Бараа материалын дансны үлдэгдэл 169,029.7 мянган төгрөг болж 3,162.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 8,409.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон хандиваар 7,650.0 мянган төгрөгийн бараа материал хүлээн авч, 12,896.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,642,318.3 мянган төгрөг болж 32,856.1 мянган төгрөгөөр буурсан нь 7,985.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлэн авсан, 158,274.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлж орлогод авсан, Мандал сумын ИТХ-ын 2021 оны 139 дүгээр тогтоолоор 59,630.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг акталсан болон 139,485.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлж, данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,544,765.0 мянган төгрөг болж 70,811.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 219,510.2 мянган төгрөгөөр буюу 34.7 хувиар өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал, үндсэн хөрөнгийн орлого 162,169.0 мянган төгрөгөөр, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 57,314.4 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант оны нийт зардал өмнөх оноос 114,724.5 мянган төгрөгөөр буюу 17.2 хувиар өссөн байна. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл, урамшуулалд 13,909.3 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 3,641.9 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 6,394.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 6,812.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 35,033.3 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг 47,995.0 мянган төгрөгөөр тус тус өссөнөөс голлон шалтгаалсан байна.



3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 798,624.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс 103,680.0 мянган төгрөгөөр бууруулж, 694,944.3 мянган төгрөгөөр батлагдсан байна.

Үүнд цалин, хөлс болон НДШ-ийн зардал 116,785.5 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 10,485.3 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 8,625.8 мянган төгрөгөөр бууруулж, урсгал шилжүүлгийг 42,425.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан нь голлон нөлөөлсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр **694,944.3** мянган төгрөгийн төсөв баталж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 694,944.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **670.745.9** мянган төгрөг буюу 96.5 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардлыг 13,199.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 10,135.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус чуулгын нэмэлт санхүүжилтийн 100130435406 тоот дансанд аймгийн Засаг даргын А/403 дугаар захирамжаар 4,820.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,772.1 мянган төгрөгийн зэрэг нийт 6,592.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, нормын хувцас зөөлөн эдлэл худалдан авахад 5,050.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 1,233.0 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 309.1 мянган төгрөг зэрэг нийт 6,592.1 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитын явцад онцлох ажил гүйлгээ, асуудал гараагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Мандал сумын Дуу бүжгийн чуулгын мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллээс 13 мэдээллийг хугацаа хоцроож, 136 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна. Дараах мэдээллийг хугацаа хоцроосон байна. Үүнд:

1. Дараа жилийн төсвийн төсөл, хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан, санхүүгийн тайлан, байгууллагын батлагдсан төсөв, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл зэрэг 8 мэдээллүүдийг тус бүр 1 удаа,
2. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийн мэдээллийг 2 удаа,
3. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааны мэдээллийг 3 удаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Мандал сумын Дуу бүжгийн чуулгын тайлант оны үйл ажиллагаанд 694,944.3 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 670,745.9 мянган төгрөгийг

зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 3.5 хувиар хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 448.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 891.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгөгдсөнийг бүрэн биелүүлж, 14,011.2 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгөгдсөнөөс шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулж байх зөвлөмжийг биелүүлээгүй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	1	448.2	1	448.2	100
Албан шаардлага	1	891.9	1	891.9	100
Зөвлөмж	3	14,011.2	2	14,011.2	66.7
Нийт дүн	5	15,351.3	5	15,351.3	88.9

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “*Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол*” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 49,534.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3,597.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 45,937.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчдад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг тухайн албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн 3 жилийн дунджаар бус сүүлийн сарын үндсэн цалингаар тооцож, дарга Б.Дэнсмаад 1,306.5 мянган төгрөг, хөгжимчин Д.Алтантүлхүүрт 1,647.0 мянган төгрөг, уртын дуучин Ү.Дэлгэрмаад 643.6 мянган төгрөг зэрэг нийт **3,597.1** мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 2.1 дэх “Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох үндсэн цалингийн хэмжээг тогтоохдоо тухайн албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн 3 жилийн дунджаар тооцно.” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэг удаагийн буцалтгүй тусламжийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд **44,765.9** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн и-баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт

хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг зөрчсөн тул төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

2. Өөрийн орлого төвлөрүүлэлттэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: 2021 оны 12 дугаар сард 4 удаагийн заал түрээсийн гэрээ байгуулж, **1,171.7** мянган төгрөгийн орлого бэлнээр төвлөрүүлж, төрийн сангийн харилцах дансанд 4-13 хоногийн дараа тушаасан байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 3.12 дэх "Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын (зарагдсан тасалбараас өөрт үлдэх хувь) тооцоог гаргаж, тайланг тушаана." гэсэн заалтууд болон санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг тус тус зөрчсөн байна. Цаашид орлого хураасан тухай бүр өөрийн орлогыг харилцах дансанд тушааж, мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгэ аймгийн Мандал сумын Дуу бүжгийн чуулга	3	49,534.7	-	-	1	3,597.1	-	-	2	45,937.6